

Түвшинширээ сумын 2021 оны 02 дугаар сарын ажлын товч мэдээ

Төрийн удирдлагын чиглэлээр:

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.9 дахь заалт, Улсын Онцгой комиссын 2020 оны 283 дугаар тогтоол зэргийг үндэслэн улсын Онцгой комиссын 2021 оны 01 дүгээр албан даалгавар болон аймгийн Засаг даргын 2021 оны А/105 “Зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай”, А/96 “Зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай” захирамж аймгийн Онцгой байдлын газраас өгсөн цаг үеийн байдалтай холбогдолтой үүрэг даалгавруудыг хэрэгжүүлэх үүднээс сумын Засаг даргын 2021 оны А/14 “Хугацаа сунгах тухай”, А/15 “Зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай”, А/16 тоот “Зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай” захирамжууд тус тус гаргаж, байгууллагуудад албан даалгавар болон захирамжуудыг хүргүүлэн, байгууллага бүр төлөвлөгөө гарган ажиллаж байна. 01 дүгээр албан даалгаврын төлөвлөгөөг 7 хоног бүр аймгийн Шуурхай штабт хүргүүлэн ажиллаж байна.

Сумын Онцгой комисс 1 удаа хуралдаж, цаг үеийн байдал болон сумын хэмжээнд хөл хорио тогтоох, сумын шуурхай штаб, хариуцлагатай жижүүр, хөдөлгөөнт эргүүл пост гаргах ажлын хуваарь зэрэг асуудлаар хэлэлцэж холбогдох ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Сумын шуурхай штабыг байгуулан 24 цагаар жижүүрлэн ажиллаж байна.

Төсөвт байгууллагууд цагдаагийн тасагтай хамтран сар шинийн баяр болон шинэ коронавирусээс урьдчилан сэргийлэх зорилгоор хөдөлгөөнт эргүүл, хяналтын постыг 02 сарын 11-аас эхлэн 02 сарын 15-ыг хүртэл хуваарь гарган ажиллуулаа.

Сүхбаатар аймгийн гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын даргын 2021 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 86 тоот Хүүхэд хамгааллын стастикийн тоон үзүүлэлт /32 хүснэгтэн/ судалгааг гаргаж явуулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2 тоот “Халдвараас урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын хэрэгжилтийг хангах үүднээс “Иргэн таны сонорт” “Ковид-19 зөвлөмж” санамж хуудаснуудыг бэлтгэн хэвлэж сумын иргэд болон аж ахуйн нэгжүүдэд тараан сурталчилсан.

Хүүхдэд тавих хараа хяналтыг чангатгах, бага насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр гэрт нь үлдээхгүй байх, ахуйн хүрээнд архидан согтуурахгүй байх, гэр бүл, үр хүүхдээ эрсдэлд оруулахгүй байх талаарх зөвлөгөө зөвлөмжийг ЕБС, СӨБ-ын багш нартай хамтарч фейсбүүкээр видео контент бэлтгэн тархааж байна.

Сумын Онцгой комиссын нөөцөд 4,4 сая төгрөгийн үнэ бүхий ариутгал халдваргүйтгэлийн бодис, хамгаалалтын хувцас, макс, био суултуур, гадна талбайн ариутгал хийх зориулалт бүхий мананцаржуулагч, зайнаас халуун хэмжигч зэрэг нэн тэргүүн шаардлагатай хэрэгслийг худалдан аваад байна.

Сумын Онцгой комиссын гишүүд гэрийн ажиглалт тусгаарлалтанд байгаа иргэдийг нэрчлэн хариуцаж өдөр бүр утсаар холбогдож, гадна ажиглалт хийж мэдээг өгч ажиллах зохицуулалтын арга хэмжээ аваад байна.УБ хотоос татан авалт болон хувийн унаагаар нийт 48 хүн ирснийг гэрийн ажиглалтанд авсан байна. Эдгээр иргэдийг сумын Онцгой комиссын гишүүд хариуцан хяналт тавьж, мөн утсаар зөвлөгөө зөвлөмж өгч ажилласан.

Орон нутгийн хөгжийн индексийг idi.nda.gov.mn сайтад шивж оруулаад байна.

Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц, Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Монгол улсын засгийн газраас ундны усны хэрэглээг чөлөөлсөнтэй холбогдуулан ундны усны худгийн үйл ажиллгааг тасралтгүй хэвийн явуулах талаар холбодох газраас зөөвөр зөвлөгөө чиглэл хүргүүлсэн уг чиглэлийн дагуу ХҮЙТЭН – 1 гүн өрмийн худагт тоолуур байршуулсан.

Аймгийн БОАЖГазраас нэн ховор ан амьтан аргаль хонинд БИО техникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх ажлыг зохион байгууллаа.

Аж ахуй албан байгууллага, айл өрхүүдийн агаар бохирдлын суурин эх үүсвэрийн тоо бүртгэл судалгааг хийж гар утсны апплекшин дээр бүртгэл мэдээллийг байршуулсан. Одоогоор 320 өрх, 30 орчим байгууллага аж ахуйн нэгж тооллогод хамрагдаад байна.

Түвшинширээ сумаас 2020 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр "Монгол улсын хошой аварга малчин"-1, Аймгийн сайн малчин-2, Сумын сайн малчин-6, Мянгат малчин-6 болзол хангасан байна.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн чиглэлээр:

ЭМД-д 21 хүний 1249800 төгрөг, СДД-д 34 хүний 1738800 төгрөг, НДШ-д 5-н байгууллагын 25399244 орлого орж байна. COVID-19 буюу цар тахалтай холбоотойгоор ЗГ-аас ААНэгжүүдийг НДШимтгэлээс чөлөөлөнө гэсний дагуу манай сум 16 ААНэгжийг сар бүр чөлөөлөлтөнд хамрагдсан.

Нийгмийн халамжийн тэтгэвэр цахим үйлчилгээнд шилжсэнтэй холбогдуулан ehalamj.mn цахим системд тэтгэвэр авч буй ахмад-3, ХБИ-54 нийт 57 иргэний мэдээллийг холбож ажиллалаа.

Алдарт эхийн 1,2 дугаар одонд 294 иргэнд 41700,0 мянган төгрөгийн тэтгэмжид хамруулсан.

Ахмад настаны тухай хуулийн дагуу жилд 2 удаа олгох насны хишгийн мөнгөн тэтгэмжид нийт 119 ахмадад 9720,000 төгрөгийн мөнгөн тэтгэмжид хамрагдсан.

Танхимын давтлага эхэлсэнтэй холбогдуулан анги танхимын ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж зайнаас халуун хэмжих суурин халуун хэмжигч ашиглаж байна. Давтлаганд хамрагдаж байгаа сурагчдын биеийн халууныг тогтмол үзэж бүртгэн ажиллаж байна. Байгууллагын хариуцлагатай жижүүр гарч орж гарч байгаа хүмүүсийг бүртгэн сурагчдын аюулгүй байдлыг хянан ажилладаг.

Мөн байгууллагаар орж гарсан бүх иргэдийн халууныг үзэж, багш ажилчдын бүртгэлийг QR кодоор өдөр тутам бүртгэн ажиллаж байгаа. Сурагчдын теле хичээл 2 дугаар сарын 01-нээс эхэлсэнтэй холбогдуулж АУБ нар сурагчдад гэрийн даалгавар, цахим хичээл үзэлтийг хянаж ангийн цахим хаягт байршуулан цаг тухайд нь шалган ажиллаж ирц мэдээг тогтмол цахимд бүртгэн ажиллаж байна

Соёл урлагийн арга хэмжээний хүрээнд номын сангаас Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн Д.Нацагдоржийн шагналт Санжийн Пүрэвийн “Уулын намар” зохиолыг цахимаар унших боломжийг олгож ажиллалаа.

Коронавирус халдварт цар тахлын үед хорио цээрийн дэглэмийг чанд сахиж 8 бүлгийн багш нар теле хичээлийн үзэлтийн тандалт судалгааг тогтмол хийж байна. Үүнд теле хичээл үзсэн 196, үзэж чадаагүй 36 хүүхэд хамрагдалт 84,1%-тай байлаа.

Мөн зөвлөгөө 1270, зөвлөмж 1120-ийг цахим хуудсаар тархааж, хандалт 849 байна.

Хүүхэд хамгааллын чиглэлээр: Байгууллагын хүүхэд хамгааллын баг зорилтот өрхийг 31 хүүхэдтэй байнга холбоотой байж тэдэнд тусламж дэмжлэгийг тогтмол үзүүлж байна. 0-12 насны хүүхэдтэй багш ажилчидаа гэрээр нь ажиллуулах нөхцөл боломжийг хангасан.

Танхимаар хичээллэх болсонтой холбогдуулж бүх багш ажилчдад УОК, БШУЯамны Сайдын тушаал, шийдвэрүүдийг танилцуулж хэрэгжүүлэх арга хэмжээ, төлөвлөгөө гарган ажиллаж байна. Мөн хүүхдүүдийг ЭМТ-тэй хамтран урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулсан. Багш ажилчдыг аймгийн нэгдсэн эмнэлэгт шинжилгээнд нь хамруулаад байна.

Хүүхдийн цэцэрлэг тусгаарлах байрыг 2 өрөөнд тохижуулж, ариутгалын материалын нөөц болон бусад зардалд 720,000 мянган төгрөг зарцуулсан.

ЕБС: КОВИД-19-ийн халдвараас уридчилан сэргийлэх зорилгоор бага, дунд сургуулийн үүдэнд гар ариутгагчтай хөлтэй халуун хэмжигчийг авч тавьлаа. 7хоногт 2-3 удаа халдваргүйтгэл хийж байна. Давтлагын үед баримтлах багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагч, сулацагчдын дэгийг танилцуулж хэлвэж байршууллаа. СОК-оос хичээл сургуулийн үйл ажиллагаа эхлэх үеийн бэлэн байдалтай танилцаж, хяналт шалгалт хийлээ.

Эрүүл мэндийн чиглэлээр:

Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа нь жигд хэвийн явагдаж байна. Амбулаторын нийт үзлэг 196 , алсын дуудлага 20, гэрийн дуудлага 12, хэвтэн эмчлүүлэгч 8, Угтах лавлах үйлчилгээгээр нийт 248.

Цар тахлын хүрээнд больниц, амбулаториороор үйлчлүүлж байгаа иргэдийг хувиарын дагуу хариуцлагатай жижүүр эмч нь үзэж үйлчилж байна. Улсын хэмжээгээр халдварт саагийн вакциныг хийж эхэлж байгаатай холбоотой сумын хэмжээнд нийт нөхөн саагийн вакцинд 210 хүүхэдийг хамаруулаад байна. 3-р сарын 1-ны өдрөөс эхлэн ЕБСургууль, СӨБ-ын байгууллагын үйл ажиллагаа эхэлж байгаатай холбогдуулан Эрүүл мэндийн төвийн Халдвар хамгааллын багийн гишүүд тухайн

байгууллагуудын ажилидад цэвэрлэгээ, үйлчилгээ, халдвар хамгаалалын сургалт сурталчилгааг хийгээд байна. Эрүүл мэндийн сайдын 375 тоот тушаалын дагуу давхардсан тоогоор 41 удаа аж ахуй нэгж байгууллагуудад тандалтыг хийж хэвшээд байна. Коронавирусын вакцин хийгдэхтэй холбоотой хөтөлбөр төлөвлөгөө, байр сав ажиллах баг, хүчний тайлан мэдээг эрүүл мэндийн газарт илгээгээд байна.

Тайлан нэгтгэсэн:

Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн

Ш.Дүүрэнбилэг

Хянасан:

Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Ж.Алтанцэцэг